



105

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/154

Улаанбаатар хот

Ур чадварын нэмэгдэл олгох
журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтлэг үйлчилгээний газрын нийт ажилтан, албан хаагчдад "Ур чадварын нэмэгдэл олгох журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Ур чадварын нэмэгдэл олгох тухай журмыг хэрэгжүүлж ажиллахыг нийт ажилтнуудад, хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт хариуцсан ажилтан /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА  ОДОНЧИМЭГ



106

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын
даргын 2015 оны 09 дугаар сарын 18-ны
өдрийн 159 дугаар тушаалын хавсралт

**АЖИЛЧИН, АЛБАН ХААГЧДАД
"УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ"**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нийтлэг үйлчилгээний газрын ажилчин, албан хаагчийн ажлын бүтээмжийг үнэлж "Ур чадварын нэмэгдэл" олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмыг мөрдөнө.

1.2 Ажилтан, албан хаагчдын ажлыг үнэлж ур чадварын нэмэгдэл олгох гэдэг нь тухайн ажилчин, албан хаагч ажлын байрны тодорхойлолтод заагдсан үүрэг, ажлын идвэх санаачлага, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрхэн биелүүлж байгааг үнэлж урамшуулахад чиглэгдэнэ.

1.3 Ажилчин, албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгохдоо шударга ил тод зарчмыг баримтална.

Хоёр. Ажилчин, албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох

2.1 Өдөр тутмын ажил үүргийг оролцуулахгүйгээр эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг буюу бусдаас илүү дэвшилтэт арга барилаар ажиллаж өндөр амжилт гаргасан, эсвэл шинийг санаачлан өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан ажилтанд ур чадварын нэмэгдэл олгоно.

2.2 Ур чадварын нэмэгдлийг зөвхөн тухайн албан тушаалыг эрхэлж буй хугацаанд, албан тушаалын цалингаас тооцож сар тутамд олгоно.

2.3 Ур чадварын нэмэгдлийн хэмжээг ажилласан жил, ур чадварын шалгуур үзүүлэлтийн үнэлгээг харгалзан ажилтан, албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 10-25 хувиар тооцон олгоно.

2.4 Ажилтан, албан хаагчдад ур чадвар олгох асуудлыг Газрын зөвлөл болон газрын даргын тушаалаар батлан гаргасан Ажлын хэсэг хариуцан гүйцэтгэнэ.

2.5 Ур чадварын нэмэгдлийг Ажлын хэсгийн гишүүд болон албадын дарга нарын саналыг үндэслэн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж газрын даргын тушаалаар олгоно.

2.6 Захиргаа, санхүүгийн албан хаагчдыг хагас бүтэн жилээр, үйлчилгээ техникийн ажилтнуудыг улирал тутам үнэлж ур чадварыг дүгнэнэ.

УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРМЫГ ДҮГНЭХ ДОТООД ХЯНАЛТ
ХАРИУЦСАН АЖИЛТНЫ ГАРЫН АВЛАГА

Тус ур чадварын нэмэгдэл олгохдоо Нийтлэг Үйлчилгээний Газрын даргын 2015 оны А/54 дугаар тушаалын хавсралтыг мөрдлөгө болгоно.

Нэг.

1. Ажлын цаг ашиглалт
2. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлсэн байдал
3. Ажлын идэвхи санаачлага, бусаддаа үлгэр дуурайлал болсон байдал
4. Олны нийтийн арга хэмжээнд оролцсон байдал /хурал зөвлөгөөн, мэдээлэлийн цаг, бүх нийтийн цэвэрлэгээ, спорт арга хэмжээ, ургац тариалалт хураалт/
5. Цагийн үеийн холбоотой бусад асуудал

Дээрхи 5 үзүүлэлт тус бүр нь 10 оноо байхаар бодож ажилтан албан хаагчид 50 хүртэлхи оноог авна.

Хоёр.

Газрын зөвлөл болон газрын даргын тушаалаар баталсан ажлын хэсэг нь улирал бүр явж ур чадвар дүгнэх үед албадын дарга нар болон байр хариуцсан менежерүүд нь өөрсдийн хариуцсан ажилтан, албан хаагчдын ур чадвар дүгнэхтэй холбоотойгоор дээрхи 5 үзүүлэлтээр урьдчилсан байдлаар дүгнэн ажлын хэсэгт танилцуулна.